



**“УЛААНБААТАР БҮК” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦААЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

2025 оны 04 дүгээр сарын 04-ний өдөр

№ 2025/01

Улаанбаатар хот

“Улаанбаатар БҮК” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурал 2025 оны 4 дүгээр сарын 4-ний өдрийн 11 цаг 10 минутанд “Улаанбаатар БҮК” ХК-ийн хурлын танхимд эхлэв. Хуралд оролцох хувьцаа эзэмшигчдийн бүртгэл 2025 оны 04 дүгээр сарын 4-ний өдрийн 11:00 цаг хүртэл явагдаж дуусав.

Хурлыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Д.Нямхүү даргалав.

Тооллогын комисс-д Д. Пүрэвцэрэн, Л. Билгүүн, Д.Ууганцэцэг нар тус тус ажиллав.

Мөн хуралд Хараат бус гишүүн Ч.Энхбат болон Гүйцэтгэх захирал Х.Золжаргал нар оролцов.

Хурлын ирц:

“Улаанбаатар БҮК” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд нийт 131 5 47 500 ширхэг саналын эрхтэй хувьцааны 128,338,950 ширхэг хувьцаа эзэмшигч буюу 97,56 хувийг төлөөлсөн 10 хувьцаа эзэмшигч оролцсон тул Компанийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 1 дэх заалтын дагуу “ирцийг хүчин төгөлдөрт тооцох” талаарх Тооллогын комиссын шийдвэрийг Комиссын дарга Д. Пүрэвцэрэн хуралд оролцогсдод танилцуулав.

Хуралд оролцсон хувьцаа эзэмшигчид:

1. Башир Мухамед /”Улаанбаатар менежмент” ХХК-ийн итгэмжлэлээр/

Хувьцааны тоо: 128 315 700

2. Даваажав овогтой Энхтуяа

Хувьцааны тоо: 110

3. Сумьяа овогтой Уранчимэг

Хувьцааны тоо: 19

4. Мягмаржав овогтой Шигшээ

Хувьцааны тоо: 11

5. Сандагжав овогтой Дашдорж

Хувьцааны тоо: 75

6. Батаа овогтой Баттулга

Хувьцааны тоо: 22 860

7. Пунцаг овогтой Цогзолмаа

Хувьцааны тоо: 50

- 8.Хүүжий овогтой Эрдэнэсанаа

Хувьцааны тоо:15

- 9.Бямбабаяр овогтой Баттүшиг

Хувьцааны тоо 10

- 10.Жадамба овогтой Энхтунгалаг

Хувьцааны тоо: 15

Хэлэлцэх асуудал:

1. **Хэлэлцэх асуудал-1:** 2024 оны компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж, батлах тухай;
2. **Хэлэлцэх асуудал-2:** Компанийн ТУЗ-ийн гишүүдийг батлах;
3. **Хэлэлцэх асуудал-3:** ТУЗ-ийн 2025 оны үйл ажиллагааны төсөв батлах;

Хурлын дарга Д.Нямхүү ээлжит хурлыг нээж, хурлын дэгийг танилцуулсныг Хувьцаа эзэмшигчид батлав.

Хурал даргалагч Д.Нямхүү Тооллогын комиссын тогтоолын шийдвэрийг танилцуулж, хурлын ирц 97.56 хувийн дүнтэй байгаа тул хурлыг нээснийг мэдэгдэв.

Хэлэлцэх асуудал-1:

“Улаанбаатар БҮК” ХК-ийн 2024 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг Гүйцэтгэх захирал Х. Золжаргал дэлгэрэнгүй танилцуулав.

Хурал даргалагч Д.Нямхүү тайлантай холбогдуулан Компани 2024 онд ашигтай ажилласан тул ТУЗ-өөс нэгж хувьцааны ногдол ашгийг 10 төгрөгөөр тооцож нийт хувьцаа эзэмшигчдэд тараах шийдвэр гаргасныг уншиж танилцуулав. Тэрээр ҮЦТХТ-өөс “Улаанбаатар БҮК”ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн дэлгэрэнгүй мэдээллийг авч чадахгүй олон жил болж байгаа, мөн ногдол ашгийг өөрийн Компани дээр тараах нөхцөл боломж байхгүй байгаа талаар тайлбар хийв.

Компанийн үйл ажиллагааны тайлангийн талаарх мэдээлэлтэй холбогдуулан хувьцаа эзэмшигч Д.Энхтуяа дараах 2 санал хүсэлтийг танилцуулав. Үүнд:

1/Өөрийн хувийн цахим шуудангаар Компанийн үйл ажиллагааны тайлан, 2025 оны зорилтот түвшингийн талаар хуралд танилцуулсан мэдээлэл ирүүлэх

2/МХБ-ийн хувьцаа эзэмшигчдийн хуралд Компанийн удирдлагаас оролцож “Улаанбаатар БҮК”ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн дэлгэрэнгүй мэдээллийг авч чадахгүй олон жил болж байгаа, мөн ногдол ашгийг өөрийн Компани дээр тараах нөхцөл боломж байхгүй байгаа талаар саналаа илэрхийлэх санал тавив.

Өөр бусад хувьцаа эзэмшигчид асуулт, санал гараагүй тул компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх “хангалттай” гэж ТУЗ дүгнэснийг батлах талаар санал хураалт явуулав.

Санал хураалтын дүнг Тооллогын комиссын дарга Д. Пүрэвцэрэн танилцуулав.

Санал хураалтын дүн:

Зөвшөөрсөн:10

Татгалзсан: 0

Санал хураалтын дүн: 100%

ШИЙДВЭР:

“Улаанбаатар БҮК” ХК-ийн 2024 оны компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг “хангалттай” гэж батлах.

Хэлэлцэх асуудал-2:

ТУЗ-ийн гишүүдийг томилох тухай:

Хурал даргалагч Д.Нямхүү ТУЗ-д 9 хүнийг нэр дэвшүүлэхээр Нэр дэвшүүлэх хорооноос гаргасан шийдвэрийг, тэдгээр гишүүдийн танилцуулгын хамт танилцуулав.

ТУЗ-д нэр дэвшүүлсэн гишүүдэд куммулятив аргаар санал хураасан дүнг Тооллогын комиссын дарга Д. Пүрэвцэрэн танилцуулав.

ШИЙДВЭР:

1. “УЛААНБААТАР БҮК” ХК-ийн ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнээр дараах нэр бүхий хүмүүсийг үргэлжлүүлэн томилох:

Ердийн гишүүд:

- 1.Д.Нямхүү
- 2.Д.Мөнхөө
- 3.Х.Золжаргал
- 4.Х.Ю.Хамхоев
- 5.О.Басанхүү
- 6.М.А.Чапанов

Хараат бус гишүүд

- 1.С.Б.Громов
- 2.Г.Ганболд
3. Ч.Энхбат

Санал хураалт куммулятив аргаар явагдсан ба дараах дүн гарсныг Тооллогын комисс мэдээлэв.

3.1.Ердийн гишүүдэд

Д/д	Нэр дэвшигч	Нэр дэвшигчдэд өгсөн саналын тоо
1	Д.Нямхүү	128,521,868
2	Д.Мөнхөө	128,316,071
3	Х.Золжаргал	128,316,128
4	О.Басанхүү	128,316,071
5	Х.Ю.Хамхоев	128,316,071
6	М.А.Чапанов	128,316,071

3.2.Хараат бус гишүүдэд

1	С.Б.Громов	128,316,071
2	Ч.Энхбат	128,316,100
3	Г.Ганболд	128,316,099

Мэдээлэл өгөх:

Гүйцэтгэх захирал Х. Золжаргал “Улаанбаатар БҮК”ХК-ийн 2025 оны эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшингийн талаар дараах мэдээллийг танилцуулав.

Компанийн 2025 оны үйл ажиллагааны төлөв байдал

1-р хувилбар буюу 2025 онд ТБД их хэмжээгээр үйлдвэрлэхгүй нөхцөлд :

Борлуулалтын төлөвлөгөө

№	Бүтээгдэхүүн	хн	2023 Гүйцэтгэл		2024 Гүйцэтгэл		2025 төлөвлөгөө	
			Хэмжээ	Орлого	Хэмжээ	Орлого	Хэмжээ	Орлого
1	Нийт ТБХЭ	м³	23,790	36,067	21,483.2	34,976.75	26,001.1	39,050
1.1	ХНХ	м³	2,398	1,144	217.5	88.9	0	0
1.2	Хоолой, цагираг	м³	2,281	2,175	2,509.6	2,495.70	3,293.61	3,256
1.3	ТЗ ТБД	м³	8,631	19,650	9,693.1	18,112.60	1,920.00	4,091
1.4	Бусад ТБХЭ	м³	10,480	13,096	9,063.1	14,279.30	20,787.45	31,703
1.4.1	Стандарт	м³	6,341	5,086	7,036.7	9,713.59	15,857.93	19,678
1.4.2	Стандарт бус	м³	4,139	8,010	2,026.4	4,565.75	4,929.52	12,025
2	Металл хийц	тн		56,5	11.24	81.00	350	500
3	Бусад элдэв			931,3		8,559.6		0
	Нийт			37,055		43,617.4		39,550

2-р хувилбар буюу 2025 онд ТБД - их хэмжээгээр үйлдвэрлэх нөхцөлд :

1.Борлуулалтын төлөвлөгөө

№	Бүтээгдэхүүн	хн	2023 Гүйцэтгэл		2024 Гүйцэтгэл		2025 төлөвлөгөө	
			Хэмжээ	Орлого	Хэмжээ	Орлого	Хэмжээ	Орлого
1	Нийт ТБХЭ	м³	23,790	36,067	21,483.2	34,976.75	48,395.8	88,437
1.1	ХНХ	м³	2,398	1,144	217.5	88.9	0	0
1.2	Хоолой, цагираг	м³	2,281	2,175	2,509.6	2,495.70	3,293.6	3,256
1.3	ТЗ ТБД	м³	8,631	19,650	9,693.1	18,112.60	31,360.0	64,727
1.4	Бусад ТБХЭ	м³	10,480	13,096	9,063.1	14,279.30	13,742.2	20,454
1.4.1	Стандарт	м³	6,341	5,086	7,036.7	9,713.59	11,272.2	15,065
1.4.2	Стандарт бус	м³	4,139	8,010	2,026.4	4,565.75	2,470.0	5,389
2	Металл хийц	тн		56,5	11.24	81.00	45.5	500
3	Бусад элдэв			931,3		8,559.6		0
	Нийт			37,055		43,617.4		88,937

Хэлэлцэх асуудал-3:

ТУЗ-ийн 2025 оны төсвийн талаар хурал даргалагч Д.Нямхүү мэдээлэл хийсэн ба Компанийн 2025 оны ТУЗ-ийн үйл ажиллагааны төсвийг **248,850.300 /хоёр зуун дөчин найман сая найман зуун тавин мянга гурван зуун / төгрөгөөр батлах** ТУЗ-ийн саналыг танилцуулж санал хураав.

Санал хураалтын дүнг Тооллогын комиссын дарга Д. Пүрэвцэрэн танилцуулав.

Санал хураалтын дүн:

Зөвшөөрсөн:10

Татгалзсан: 0

Санал хураалтын дүн: 100%

ШИЙДВЭР:

Компанийн 2025 оны ТУЗ-ийн үйл ажиллагааны төсвийг 248,850.300 /хоёр зуун дөчин найман сая найман зуун тавин мянга гурван зуун / төгрөгөөр батлах

Хурал дэгийн дагуу 15.20 цагт дуусав.

Хурлын тэмдэглэл хөтөлсөн :.....Л.Билгүүн.....
/Тооллогын комиссын гишүүн Л.Билгүүн/